

ИТАЛИЙН АЛДАРТ ЗАГВАР ЗОХИОН БҮТЭЭГЧ САВЕРИО ПАЛАТЕЛЛА “ГОВЬ” ХК-Д ЗОЧИЛЛОО

Ж.СОЛОНГО

Италийн алдарт загвар зохион бүтээгч Саверио Палателла Монгол орныг тэр дундаа ноолуурын салбарт тэргүүлэгч “Говь” ХК-ийг зорин иржээ. Тэрбээр Парисын олон улсын хувцас загварын “Эколе Перкот” сургуулийг 1980 онд сүлжмэл эдлэлийн зохион бүтээгч мэргэжлээр тогсож одоо Европын шилдэг найман загвар зохион бүтээгчийн нэг болтлоо алдаршаад байна. Мөн 1993 оноос дэлхийд алдартай “Malo”, “Cuccinell” зэрэг ноолууран бүтээгдэхүүний томоохон брэндүүдийн үйлдвэрлэлийн зөвлөлд орж ажиллах болжээ.

Итали, Герман, Америк, Япон, Орос зэрэг оронд өөрийн нэрийн бүтээгдэхүүнээ худалдаалагч Саверио Палателла энэ удаа “Говь” ХК-д өөрийн сонирхлын дагуу хоёр тал хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх зорилготой ажиллаж буй. Түүнийг ноолуурын үйлдвэртэй танилцаж, “Говь” ХК-ийн загвар зохион бүтээгчидтэй уулзаж, зөвлөгөө өгч байх үед нь түр саатуулан ярилцлаа.

-Юуны өмнө манай орныг зорин ирж, “Говь” ХК-ийн үйлдвэр болон бүтээгдэхүүнтэй нь танилцаж байгаад талархал илэрхийлье. Энэ бүтцийг хараад төрсөн анхны сэтгэгдэлээ хуваалцана уу?

-Монголын хувьд ямаа болон ноолуур нь эх орондоо байгаа гэдгээрээ онцлогтой. Түүнээс гадна түүхий эдлээ боловсруулан эцсийн бүтээгдэхүүн гаргах хүртлээ ажиллаж чаддаг дэлхийн түвшинд хүрсэн томоохон үйлдвэр танайд байна. Ноолуурт байх ёстой байгалийн дорвон өнгө танайд бүрэн байна шүү дээ.


-Та яагаад сүлжмэл эдлэл, ноолуурыг сонгон уран бүтээлээ хийх болсон бэ?

-Ноолуур, сүлжмэл эдлэлийн чиглэлийн үйлдвэрлэл эрхэлдэг гэр бүлд төрж, өссөн учраас бага байхаасаа энэ салбарыг сайн мэддэг байсан. Тиймдээ ч энэ зүгт татагдан, уран бүтээлээ хийх болсон.

-Дэлхийн загварын чиг хандлагад ноолуур ямар байр суурь эзэлж байна вэ?

-Ноолууран бүтээгдэхүүнийг сүүлийн 15 жилийн турш дунд болон дээд түвшинд өргөн хэрэглэх болсон. Түүнээс өмнө ноолуурыг тансаг хэрэглээнд тооцдог байлаа. Одоо бол ноолуур ялангуяа Итали, Францад түгээмэл хэрэглээ болоод байна.

-Тэгвэл Та ноолуурыг дээд



түвшинд зориулсан тансаг хэрэглээ байх ёстой гэж бодож байна уу эсвэл хүн бүхэнд хүртээмжтэй өдөр тутмын хэрэглээ болгохыг зорьж байна уу?

-1960-1980-аад онд ноолуур тансаг хэрэглээ байсан бол 1980 оны дунд үеэс дунд түвшний хэрэглэгчдэд түгээмэл хүрч болсон. Гэхдээ загвар хийш, чамин тансаг байдлаараа ялгарч болох учраас хүн бүрт хүргэх боломжтой.

-Манай загвар зохион бүтээгчдийн бүтээлийг хараад ямар дүгнэлт хийв ээ?

-Энд байгаа загваруудаас харахад монголчууд тэр дундаа “Говь” ХК-ийн хэрэглэгчид сонгодог хэв маягаар хувцасладаг юм уу гэсэн сэтгэгдэл төрж байна.

-Харин загвар зохион бүтээгчийн ур чадварын хувьд...

-Загвар зохион бүтээгчид хэрэглэгчдийн захиалгаар бүтээгдэхүүн хийж байгаа үед ур чадварыг шууд дүгнэх боломжгүй. Харин чөлөөтэй сэтгэх бололцоо олговол өөр дүгнэлт гарна байх. Тэр ч утгаараа “Говь” ХК фэйшин коллекциуд гаргаад эхэлчихсэн байна.

-“Говь” ХК гадаадын зах зээлд багагүй нэр хүндтэй болсон. Харин эдгээр загваруудаараа хүрээгээ өргөжүүлж хүн бүрт хүрэх боломж бий юу?

-Ямар ч асуудал байхгүй, болно.

-Европын ноолуурын үйлдвэрүүдийн боловсруулалтыг Монголтой харьцуулж болох уу?

-Шууд харьцуулж болохгүй. Монголчууд цэвэр ноолуур дээр ажиллаж байна. Харин бид олон зуун жилээр уламжлагдаж тогтсон хэв маяг,

боловсруулах дэг жаягаар дээд зэргийн утас гаргах технологитой.

-Монголын цаг уур эрс тэс. Түүний зэрэгцээ энэ зун их халуун болж байна. Энэ нөхцөлд ноолуур өмсөх нь хэр тохиромжтой юм бол?

-Гэхдээ өглөө, оройдоо сэрүүхэн учраас өмсөхөд тохиромжтой байлгүй яах вэ.

-Танд манайхан хамтран ажиллах санал тавибал зөвшөөрөх үү?

-Миний хувьд хамтран ажиллахад татгалзах зүйлгүй гэж бодож байна. Тэгээд ч энэ удаа ирсэн маань нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, “Говь” ХК-ийн талаар илүү их мэдээлэлтэй болох зорилготой юм.

-Ирэхээсээ өмнө Монгол орныг судлаж уу, хаана очиж үзэхийг хүсэж байна вэ?

-“Говь” ХК-тай танилцах саналыг хүлээж аваад удалгүй Монголд ирсэн. Энд ажиллахын тулд богино хугацаанд их материал бэлтгэх шаардлагатай байсан учраас Монголын талаар судалж амжаагүй. Тэнд, энд очихсон гэж төлөвлөөгүй ч Монгол орныг эртний түүх, байгаль, соёлоороо гайхагдлагийг мэднэ. Энэ удаагийн хамтын ажиллагаа амжилттай болж, дараа дахин ирэх боломж гарвал үзэх зүйл их байна. Шахуу төлөвлөгөөтэй ч гэсэн ноолуурын эх оронд хол танилцлаа баяртай байна.

-Хэдий богино хугацаатай ажиллаж байгаа ч энд байхдаа өөрийн ирээдүйн загварын гайхалтай шийдлийг олохыг хүсэн өрөө.

-Та бүхнийг хүрэлцэн ирж ярилцлагад урьсанд баярлалаа.

